



PROFESSIONAL TRAINING COLLEGE in JAPAN GUIDE BOOK

Дэлхийд ажил олоход хамгийн хялбар орон “Япон”

Мэргэжлийн технологи+Найрсаг зочломтгой байдлаараа Азид анхаарал татаж байна!

Японы Professional Training College-д тавтай морилно уу!

~Ministry of Education, Culture, Sports, Science and Technology, Lifelong Learning Policy Bureau, Lifelong Learning Promotion Division, Office for the Promotion of Specialized Training College Education илгээх мессеж~

Японд ажлын ур чадвар эзэмшихийг эрмэлзэж буй хүмүүст

Японы Professional Training College нь 1976 онд түүний тогтолцоог бүрдүүлснээс хойш уян хатан бөгөөд харилцан уялдаат тогтолцооны онцлог байдлыг ашиглан нийгмийн өөрчлөлтөнд зохицсон практикт ойр мэргэжлийн боловсрол олгох гол байгууллага болон хөгжиж ирсэн. Одоогийн байдлаар 590 мянган оюутан суралцаж байгаа ба Япон улсын дээд шатны боловсролын байгууллагуудын дунд чухал орон зайг эзэлж байна.

Professional Training College нь Technology, Agriculture, Medical Care, Personal Care and Nutrition, Education and Welfare, Business, Fashion and Home Economics, Culture and General Education гэсэн 8 салбарт бодитоор ашиглагдах мэргэжлийн ноухауг эзэмшүүлж байна. Тэр дундаа сүүлийн үед дэлхий нийтийн анхаарлыг татаж буй манга, аниме, тоглоом, фейшн зэрэг “cool Japan” гэгдэх поп соёлоос эхлээд байгаль орчин, эрчим хүч, IT, нийгмийн дэд бүтэц зэрэг цаашид дэлхийн зах зээлд өсөх ирээдүйтэй аж үйлдвэрийн салбарыг гардан авч явах мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэж байна.

Японд Professional Training College нь нийгмийг авч явах чухал боловсон хүчнийг бэлтгэж буй сургууль гэдгээрээ хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд Professional Training College-ийг төгссөн оюутнууд ажлын байран дахь мэргэжлийн технологийг эзэмшсэн хэмээн үнэлэгддэг.

Мөн эдийн засгийн нөхцөл байдлаас үл хамааран тэдний хөдөлмөр эрхлэлтийн хувь өндөр хэвээр байсаар байна. Түүнчлэн дэлхийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй олон Япон корпорациуд нь гадаад улс оронтой Японыг холбох гүүр болох хүний нөөцийг байнга эрэлхийлж байгаа бөгөөд мэргэжлийн технологи, Япон соёл суралцаж буй Professional Training College-ийн гадаад оюутнуудыг маш ихээр сонирхох болсон.

Японы Professional Training College-д суралцаж, практикт ойр мэргэжлийн ур чадварыг эзэмшсэн мэргэжилтэн болж дэлхийн хэмжээнд ур чадвараа гайхуулах боломж олгож байна.

Найрсаг зочломтгой байдал

Япон

Эрүүл мэнд

Эмчилгээ, нийгмийн халамж

Фейшн

IT, WEB

Технологи

Соёл
аниме

Сүүлийн жилүүдэд Зүүн өмнөд азийг хамарсан Азийн эдийн засаг, аж үйлдвэрлэл хурдацтай хөгжиж тэр дундаа дэлхийн эдийн засгийг урагш татах хэмжээний томоохон корпорациуд бий болж байна. Энэ нь хөгжиж буй орнуудад мөн хамаатай ба технологи, дэд бүтцээс эхлээд гадаадын улс орнуудын аж үйлдвэрлэл, хүнсний үйлдвэрлэл, фейшн болон гоо сайхан, медиа зэрэг салбаруудад олон төрлийн ажил мэргэжлийн аутсорсингийн гол түшиц газар гэдэг утгаараа ч дэлхий дахины анхаарлыг татаж байна.

Япон нь өдийг хүртэл аж үйлдвэрлэлийн олон салбарт “Японы технологийн чадамж” болон “Зарчимч бөгөөд найрсаг зочломтгой сэтгэл зүй”-дээ тулгуурлан гадаадын олон улс орны хөгжилд хувь нэмэр оруулж ирсэн. Түүний үндэс суурь болсон мэргэжлийн боловсролын байгууллага нь чухамхүү “Professional Training College” юм.

Улсаас тогтоосон албан ёсны боловсролын байгууллага бөгөөд ажил эрхлэхэд чиглэгдсэн олон төрлийн сертификатыг олгодог мэргэжлийн сургуульд гадаадын оюутнууд жилээс жилд япон орныг зорин ирдэг ба одоогийн байдлаар 59,000 оюутан болоод байна. Япон нь мэргэжлийн технологи болон мэргэжлийн зэргээс гадна амьдрахад аюулгүй, ажил олоход хялбар мөн аниме, хоол хүнс, байгаль, өвөрмөц соёлоороо анхаарал татаж байна. Японы “Professional Training College”-д төрөл бүрийн ур чадвар, соёл суралцаж, Япон компанид ажилд орох болон өөрийн орны томоохон компаниудад ур чадвараа гайхуулахын төлөө нэг алхам урагшилцгаая.

Өндөр мэргэжлийн ур чадвар, мэргэжлийн зэрэг, технологийг эзэмших.

Японы Professional Training College

Ажлын байранд шууд холбох Professional Training College-ийн сургалт

Professional Training College нь практикт ойр мэргэжлийн боловсрол олгох Японы дээд шатны боловсролын байгууллага. Ажил мэргэжил болон бодит практикт шаардлагатай мэдлэг, технологи, ур чадварыг эзэмшүүлэх, сурган хүмүүжүүлэх зорилго бүхий боловсролын байгууллага бөгөөд Medical Care, Technology, Culture and General Education, Business, Personal Care and Nutrition, Education and Welfare, Fashion and Home Economics, Agriculture зэрэг төрөл бүрийн салбарын сургуулиудтай.

Японы Professional Training College


Сургуулийн тоо: 2,822

Элсэгчдийн тоо : 268,654 хүн

Оюутны тоо: 588,223 хүн (2017 оны 5 сарын байдлаар)

Японы Professional Training College-ийн статус

Японы боловсролын системд Professional Training College нь их сургууль, коллежийн нэгэн адил "дээд шатны боловсролын байгууллага"-ын статустай ба Японы дээд шатны боловсролын тогтолцоон дунд мэргэжлийн боловсролыг хариуцаж буй байгууллага болно. Одоогийн байдлаар 2-с дээш жилийн сургалттай (нийт хичээлийн цаг 1,700 цагаас дээш) ангийг дүүргэсэн оюутанд "Diploma", 4-с дээш жилийн сургалттай (нийт хичээлийн цаг 3,400 цагаас дээш) ангийг дүүргэсэн оюутанд "Advanced Diploma" цол олгох ба "Diploma"-тай төгсөгч их сургуульд дэвшин суралцах, "Advanced Diploma"-тай төгсөгч магистрын хөтөлбөрт хамрагдах боломжтой болно.



Professional Training College-ийн онцлог


Улсаас олгодог мэргэжлийн зэргийг авах зэрэг олон олон давуу тал бүхий Professional Training College

Японы Professional Training College-ийн хамгийн том онцлог нь ажлын байранд шууд холбоотой байдаг явдал юм. Бүхий л мэргэжлийн салбарт өндөр мэргэжлийн технологийг эзэмшүүлэх зорилготой боловсролын байгууллага бөгөөд их сургуулийн дараа орох дээд шатны боловсролын байгууллага гэдгээр чухал байр суурийг эзэлж байна.

Ажил олоход хялбар бөгөөд их сургуульд дэвшин суралцах боломжтой



Professional Training College нь нийгмийн эрэлтэд нийцүүлэн аж үйлдэрийн салбартай байгаа харилцаа холбоотой ажилтан юм. Мэргэжлийн боловсрол олгох боловсролын байгууллагын хувиар ажлын байрны шагуурыг хангасан хүний нөөцийг бэлтгэн гаргасар ирсэн амжилт нь төгссөн оюутнуудын ажил эрхлэлтийн хувь өндөр байдагтай шууд хамааралтай. Мөн боловсролын өндөр чанар нь их сургуулиудад өндөрөөр үнэлэгддэг ба 2 жилийн курсыг дүүргэсэн оюутнууд их сургуульд дэвшин суралцах боломж нь нээлттэй байдаг.



Дэлхийд хүлээн зөвшөөрөгдөх мэргэжлийн технологи, мэдлэгийг эзэмшүүлэх

Одоогийн байдлаар технологи, дэд бүтэц, хоол хүнсний салбар, аялал жуулчлал, мөн фэйшн, медиа салбарт хүртэл Японы өндөр технологи нь дэлхий нийтийн анхаарлыг зүй ёсоор татаж байна. Эдгээр өргөн хүрээний мэргэжлийн мэдлэгийг өндөр түвшинд сурч эзэмших боломжтой боловсролын байгууллага нь Японы Professional Training College юм.

Боловсролын орчин, хичээлийн байр, тоног төхөөрөмж бүрэн хангагдсан

Жишээ нь аниме, дизайн зэрэг медиа чиглэлийн сургууль бол оюутан нэг бүрт 1 компьютер өгөгдөж, хоол хүнсний чиглэлийн сургууль бол сүүлийн үеийн хоол бэлтгэх хэрэгслүүдийг ашиглан дэлхийн трендийг сурах боломжтой байх зэрэг боловсролын чанарыг өндөр түвшинд хадгалсан тулд бүрэн тоноглогдсон бааз дээр суралцах боломжтой.

Technical Skill Мэргэжлийн өндөр ур чадвар эзэмших

Professional Training College-ийн багш нар бүгд тухайн салбарынхаа мэргэжилтнүүд байдаг. Тиймээс тэндээс олж авах мэдлэг нь ч тухайн салбарт шууд ашиглагдах топ зэрэглэлийнх байдаг гэж хэлж болно. Мөн интерншип буюу дадлагын ажлыг идэвхтэйгээр зохион байгуулдаг сургууль олон байдаг ба сургуульд сурах хугацаандаа Япон компаниудын ноухауг сурч мэдэх бодомжтой. Технологи, автомашин, гэрийн цахилгаан хэрэгсэл, фэйшн зэрэг салбаруудад аль хэдий нь дэлхийд танигдсан Япон компаниудын ноухаугай танилцах нь та бүхэнд том цочроо өгөх нь дамжиггүй.



Hospitality Япончуудын найрсаг зочломтгой зан

Сүүлийн жилүүдэд Токиогийн Олимпын сонгон шалгаруулалтын илтгэлийн үед мөн яригдаж байсанчлан Япон нь өндөр мораль, ёс суртахууныг дээдэлдэг "Найрсаг зочломтгой орон". Аялал жуулчлал болон хоол хүнсний салбар, эмчилгээ, боловсролын салбар зэрэг бүхий л чиглэлд өндөр түвшний "найрсаг зочломтгой" байх ур чадвар шаардагддаг тул "Японд байх төдийд өдөр тутам ийм техникийг ойроос мэдэх боломжтой" байдаг нь маш том давуу байдал гэж хэлж болно.

Японы эрдмийн зэрэг, цол

Боловсролын байгууллагуудын ангилал	Япон дахь эрдмийн зэрэг	Боловсролын байгууллагуудын ангилал	Япон дахь эрдмийн цол
Graduate School	Doctorate degree Master's degree	Professional Training College	Advanced Diploma Diploma
University/College	Bachelor's degree		
Junior College	Associate degree		

*2-с дээш жилийн сургалттай мэргэжлийн ангийг дүүргэвэл "Diploma" цол, 4-с дээш жилийн сургалттай ангийг дүүргэвэл "Advanced Diploma" цол олгодог.

Олон төрлийн мэргэжлийн катогорид зохицсон мэргэжлийн боловсрол болон өргөн сонголтот ажлын байр

Ягаад Professional Training College-ийн төгсөгчдөд ажлын байр олон байдаг вэ? Яагаад гэвэл тухайн салбарт "мэргэжлийн" гүнзгийрүүлсэн боловсрол олгодог болохоор тэр. Тухайн салбарт төрөлжсөн олон факультеттэй ба эмчилгээ, халамж үйлчилгээ, хүүхэд асаргаа, багш, гоо сайхан, нүүр будалт, хоол, талх, нарийн боов үйлдвэрлэл, хоол тэжээл, зочид буудал, аялал жуулчлал, зам тээвэр, спорт, нийгмийн халамж, гэрийн тэжээвэр болон мал амьтан, хувцас, фейшн, дуу хөгжим, хөгжмийн зэмсэг, хэвлэл мэдээлэл, соёл урлаг, зохиол нийтлэл, програм хангамж, компьютер, тоглоом, дуу оруулах, манга, аниме, дизайнер, дүрслэх урлаг, уран бичих урлаг, барилга, зам гүүр, интерьер дизайн, төрийн алба, бизнес, авто механик, авто спорт, цахилгаан, электроник, байгаль орчин, биотехнологи, газар тариалан, хими, онгоцны засвар үйлчилгээ, нисгэгч... зэрэг өөрийн "юу болохыг хүсч байгаа"-даа тохируулан сургуулиа сонгох нь чухал болно.

Жил болгон олон олон гадаад оюутнууд Японд суралцаж байна.



Professional Training College-д элсэн орох шалгуур болон Diploma, Advanced Diploma.

Элсэн орохын тулд; Дор дурьдсан нөхцлөөс аль нэгийг нь хангаж байх шаардлагатай.

- ① Гадаад ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийг дүүргэсэн этгээд
- ② Гадаад дахь 12 жилийн сургалтыг дүүргэсэнтэй тэнцэхүйц хэмжээний мэдлэгийн түвшинг тогтоох шалгалтад тэнцсэн ба 18 нас хүрсэн этгээд
- ③ Японд гадаадын ахлах сургуультай тэнцэнэ гэж заагдсан гадаад хүүхдүүдийн сургуулийг төгссөн ба 18 нас хүрсэн этгээд
- ④ International Baccalaureate, Abitur, Baccalaureate дипломтой ба 18 нас хүрсэн этгээд
- ⑤ Япон дахь олон улсын үнэлгээний байгууллага (WASC, CIS, ACSI)-аас магадлан итгэмжлэгдсэн гадаад хүүхдүүдийн сургуулийн 12 жилийн сургалтыг дүүргэсэн ба 18 нас хүрсэн этгээд
- ⑥ Professional Training College-ийн ганцаарчилсан элсэлтийн комиссын шалгалтын дүнд ахлах сургуулийг төгссөнтэй дүйцэхүйц түвшний боловсролтой гэж хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд 18 нас хүрсэн этгээд

①~③-ийн тухайд 12 жилээс бага боловсролын тогтолцоотой тохиолдолд дараах байдлаар элсэлтийн шалгуурыг хангах шаардлагатай.

Энэтхэг, Филиппин, Малайз зэрэг 10 эсвэл 11 жилийн сургалттай сургуулийг төгссөн этгээд байх тохиолдолд;

- ① Өөрийн орны их сургууль зэрэг дээд шатны боловсролын байгууллагад 1 эсвэл 2 жил суралцаж, нийт 12 жилийн боловсрол эзэмшсэн байх
- ② Их сургуульд элсэн ороход зориулсан боловсролын бэлтгэл сургалт гэж албан ёсоор тогтоосон курст 1 эсвэл 2 жил суралцсан байх.

Япон хэлний түвшин Дараах аль нэг шалгуурыг хангасан байх шаардлагатай.

- ① Хууль зүйн сайдын албан ёсоор зарласан Япон хэлний боловсрол олгох байгууллагад 6 сараас дээш хугацаанд Япон хэлний сургалтанд хамрагдсан этгээд
- ② Японы олон улсын боловсролыг дэмжих нийгэмлэг болон Олон улсын харилцааны сангаас эрхлэн явуулдаг "Япон хэлний түвшин тогтоох шалгалт"-ын N1 эсвэл N2 түвшинд тэнцсэн этгээд
- ③ Японы бага, дунд, ахлах сургуульд 1-ээс дээш жил суралцсан этгээд (Ясли цэцэрлэгийг оруулахгүй)
- ④ "Independent Administrative Institution Japan Student Services Organization"-с зохион явуулдаг Япон улсад суралцах шалгалтын "Япон хэл (Унших, Сонсох, Сонсоогоо уншиж ойлгох хэсгийн нийлбэр дүн)"-ний 200-с дээш оноо авсан этгээд
- ⑤ Япон ханзны түвшин тогтоох нийгэмлэгээс эрхлэн явуулах BJT бизнесийн Япон хэлний тестийн 400-аас дээш оноо авсан этгээд

Төлбөрийн чадамж

Гадаадад суралцахтай холбоотой сургалтын төлбөр болон суралцах хугацааны амьдралын өртгийг төлөх зэрэг манай улсад сурч амьдрахад бололцооны түвшний эдийн засгийн суурьтай байх.

"Diploma", "Advanced Diploma" цол олгох шалгуур





	Diploma	Advanced Diploma
Элсэн орох хугацаа	4 сар (Зарим нь 10 сард элсэх)	4 сар (Зарим нь 10 сард элсэх)
Хичээлийн жил	2 жилээс дээш	4 жилээс дээш
Хичээлийн цаг	1,700 цагаас дээш	3,400 цагаас дээш
Төгссөнийг гэрчлэх	Шалгалтаар сурлагын дүнг үнэлж курсыг дүүргэсэн болохыг гэрчлэх	Шалгалтаар сурлагын дүнг үнэлж курсыг дүүргэсэн болохыг гэрчлэх
Курсын сургалтын төлөвлөгөө	—	Сургалтын хөтөлбөрийг системтэйгээр төлөвлөсөн байх

Өргөдөл гаргахад шаардлагатай бичиг баримт

- Сургууль бүрт харилцан адилгүй байх боловч нийтлэгээр дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг элсэхийг хүссэн сургуульдаа шууд хандан авна уу.
- ① Элсэлтийн өргөдөл (Сургуулиас заасан маягт)
 - ② Ахлах сургууль төгссөн гэрчилгээ
 - ③ Хамгийн сүүлд төгссөн сургуулийн дүнгийн хүснэгт
 - ④ Японы боловсролын байгууллагад суралцсан дүнгийн хүснэгт (Япон улсад оршин суудаг тохиолдолд)
 - ⑤ Япон хэлний түвшинг тодорхойлох гэрчилгээ (Гадаадад оршин суудаг тохиолдолд)
 - ⑥ Эрүүл мэндийн байдлын тухай тодорхойлолт
 - ⑦ Цээж зураг
 - ⑧ Сургалтын төлбөрийг төлөх санхүүгийн чадамжийг нотлох бичиг баримт (Өргөдөл гаргагчын өөрийн эсвэл түүний батлан даагчын банкны дансны хуулга зэрэг)

Нэгэн зөвлөгөө! Professional Training College-ийн элсэлтийн шалгалт

Элсэлтийн шалгалт нь аль ч салбарт зорилгоо тодорхой тодорхойлсон эсэх, элсэн орсны дараа хичээлийг ойлгох хэмжээний Япон хэлний мэдлэг болон суурь мэдлэгтэй эсэх, сурах хүсэл эрмэлзэлтэй эсэх гэсэн шалгууруудаар голчлон дүгнэнэ.

	Өөрийн авъяасыг хөгжүүлмээр байна. (Culture and General Education, Personal Care and Nutrition, Fashion and Home Economics)	Юм зохион бүтээх ажилд сонирхолтой (Technology, Agriculture)	Бизнесийн салбарын мэргэжилтэн болмоор байна (Business)	Хүнд тусалдаг ажил хиймээр байна. (Medical Care, Education and Welfare)
	Фейшн, гоо сайхан, хоолны технологитэй холбоотой ажил хийх хүсэлтэй. Дуу хөгжим, дизайн, гадаад хэлний мэдлэгээ ашиглан ажиллах сонирхолтой. Өөрийн мэдрэмж, авъяасыг хөгжүүлэн технологи, мэдлэгийг гүнзгийрүүлэн эзэмших.	Машинд дуртай, робот зохион бүтээмээр байна. Цахилгаан, шинжлэх ухаан технологи, газар тариаланд сонирхолтой хүмүүст. Хамгийн сүүлийн үеийн технологид суралцаж, зохион бүтээх талбарт хүчээ сорих боломж олгох орчин үеийн боловсролыг олгож байна.	Хамгийн сүүлийн үеийн мэдээллийн технологи, нягтлан бодох бүртгэлийн мэдлэгт суралцуулж, орчин үеийн эдийн засаг нийгэмд уялдан олон талт хүний нөөцийг бэлтгэж байна. Бизнесийн салбарт мэргэжилтнүүд бэлтгэн гаргаж байгаа ба ямар ч компанид ажиллах боломжтой.	Хүнд тусламаар байна. Эмчилгээ, асаргааны талбарт ажиллах сонирхолтой. Ийм мөрөөдлийг биелүүлэхийн тулд тухайн ажлын мэргэжлийн мэдлэг, технологид суралцан, мэргэжлийн зэрэг авахын хамт ажлын хариуцлага болон бусдад туслах харамгүй сэтгэл зүйд сургахыг зорьж байна.
Гол салбар чиглэл	<ul style="list-style-type: none"> •Гоо сайхан •Дизайн •Хоол, талх, нарийн боов үйлдвэрлэл, •Дуу хөгжим •Гадаад хэл •Мал амьтан •Фейшн бизнес •Кино, нэвтрүүлэг зэрэг 	<ul style="list-style-type: none"> •Мэдээлэл боловсруулалт •Авто механик •Зам гүүр, барилга •Цахилгаан, электроник •Тоног төхөөрөмж •Биотехнологи г.м 	<ul style="list-style-type: none"> •Бизнес •Аялал жуулчлал •Нягтлан бодох бүртгэл •Мэдээлэл •Худалдаа •Менежмент •Нарийн бичиг г.м 	<ul style="list-style-type: none"> •Сувилгаа •Физик болон хөдөлмөр эмчилгээ •Шүдний эрүүл ахуйч •Жүдогийн бариа засал •Асаргаа халамж г.м
Болон шаглалтаар олж авах зэрэг Төгссөний дараах мэргэжлийн зэрэг	<ul style="list-style-type: none"> •Гоо сайханч •Хүнсний технологич •Талх, нарийн боовны эрүүл ахуйч •Фейшн бизнесийн түвшин тогтоох шалгалт •TOEIC г.м 	<ul style="list-style-type: none"> •Мэдээлэл боловсруулалтын техникчийн шалгалт •Авто механикч •Архитектор •Цахилгаанчин •Онгоцны механикч •Төсөвчин г.м 	<ul style="list-style-type: none"> •Татвар бодогч •Аялал жуулчлалын үйл ажиллагаа хариуцсан менежер •Бүртгэлийн шалгалт •Нарийн бичгийг шалгалт •Бизнесийн түвшин тогтоох шалгалт г.м 	<ul style="list-style-type: none"> •Сувилагч •Шүдний эрүүл ахуйч •Физик эмчилгээний эмч •Хөдөлмөр эмчилгээний эмч •Асаргаа халамжийн мэргэжилтэн •Лаборант г.м 
Зорьж буй мэргэжил	<ul style="list-style-type: none"> •График дизайнер •Фейшн дизайнер •Зураач чимэглэгч •Орчуулагч, хөтөч •Гоо сайханч •Хүнсний технологич •Талх, нарийн боовны технологич 	<ul style="list-style-type: none"> •Системийн инженер •IT техникч •Тоглоом зохион бүтээгч •Авто механикч •Архитектор •Өргөн нэвтрүүлгийн техникч г.м 	<ul style="list-style-type: none"> •Аялалын үйлчилгээний ажилтан •Зочид буудлын ажилтан •Татвар бодогч •Эмнэлгийн ажилтан •Нарийн бичиг •Онгоцны үйлчлэгч г.м 	<ul style="list-style-type: none"> •Сувилагч •Шүдний эрүүл ахуйч •Физик эмчилгээний эмч •Хөдөлмөр эмчилгээний эмч •Оношлогооны рентген технологич •Хараа засалч •Асран сувилагч г.м

* Professional Training College-ийг төгссөний дараа мэргэжлийн зэрэг авсан ч гадаад оюутан болгон Японд ажилд орох нь хязгаартай тул энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тухайн сургуулиасаа тодруулна уу. * 2018 оны 2 сарын байдлаар. Дээр бичигдсэнээс гадна өөр олон төрлийн сертификатын шаардлага тавигдах тохиолдол ч байдаг.

Төрөл бүрийн элсэлтийн арга зам ба өргөжих боловсролын карьер



Сурч буй оюутан



Япон хэлний сургууль → Professional Training College

“30-аад насандаа өөрийн компанитай болно” гэж аав, ээждээ өгсөн амлалтаа биелүүлмээр байна

Osaka Information and Computer Science College
DAVAADORJ TELMUUN

Сүлжээний аюулгүй байдлын талаар сурахын тулд их сургуулиасаа чөлөө аван IT салбар өндөр хөгжсөн орон болох Японд хүрэлцэн ирсэн. Японы их сургуульд орох тухай бодсон хэдий ч дадлагын ажил түлхүү ордөг, технологийг сурахад илүү ойр гэдгээр нь Professional Training College-ийг сонгосон ба мөн дахвар програм хангамжийг судалж байна. Гадаадад суралцахдаа 30-аад насандаа өөрийн компанитай болно гэж аав, ээждээ амласан тул эхний ээлжид инженерээр ажиллан туршлага хуримтлуулсныхаа дараа өөрийн бизнесийг эхлүүлэх бодолтой байна. Япон улс нь амьдрахад таатай, тайван хичээлээ хийх орчин нөхцөл бүрдсэн байдаг тул зөвхөн нэг команд баригдалгүй олон зүйлд өөрийгөө сорилд үзээрэй.



Сурч буй оюутан



Япон хэлний сургууль → Professional Training College

Япон оюутнуудтай хамт суралцах боломжтой мөн хичээлээр мораль, ёс журамд суралцах боломжтой.

Japan College of Foreign Languages
SEDJAV TUVSHINZAYA

Эх орондоо байхаас л “Япон хэл шаарддаг ажил хийх сэн” гэж маш их боддог байсан. Япон хэлийг сурахад Япон руу явах нь л хамгийн зөв гэж үзэн Японд сурахаар шийдсэн. Бизнес болон компьютерийн талаарх мэдлэг мөн англи хэл зэрэг сурсан зүйлс бүгд хэрэг болж байна. Япон оюутнуудтай хамт суух хичээлүүд байдаг ба тэдэнтэй хамт сурснаар их цочроо авдаг. Ямар ч үед мораль, ёс журмыг чухалчлах Япон хүмүүсийн соёлч боловсон занд суралцамаар санагддаг. Ажилд орох үед заавар зөвлөгөө өгдөг найрсга сургууль болохоор би ч бас төгсөөд Японд ажиллах бодолтой байна.

Сурч буй оюутан



Гадаад → Professional Training College

Янз бүрийн орны хүмүүстэй англи хэлээр ярилцаж ойлголцдог болсон

Tohoku Foreign Language & Tourism College
ZORIGTBAATAR
ALTANTUUL

Япон шиг өндөр хөгжилтэй орны шинжлэх ухаан технологийг эзэмшин, түүнийгээ эх орондоо ашиг тустайгаар ашиглахын тулд Японд сурахаар шийдсэн. Анх сургуульдаа англи хэлний ямар ч мэдлэггүй орсон ба 2 жил сураад олон орны хүмүүстэй харилцаж чадах түвшинд хүрсэн. Богино хугацаанд бодит мэдлэг чадвар эзэмшүүлж өгсөн багш нартаа талархаж байна. Япон улс нь аюулгүй бөгөөд амьдрахад тав тухтай, хичээлдээ шамдан суралцах нөхцөл бүрдсэн орон. Гадаадад сурахаар төлөвлөж буй та бүхэн ч гэсэн өөр бусад орны соёлыг судлангаа оюутан насаа сэтгэл хангалуун өнгөрүүлээрэй.

Төгсөгч



Гадаад → Professional Training College → Японд ажиллаж байгаа

Монголын агаарын тээврийн салбарт хувь нэмэр оруулмаар байна

Миний ээж Япон хэлний орчуулагч байсан тул бага байхаасаа л Япон хэлтэй ойр байсан. Япончуудын амьдралын хэв маяг болон Япон сэтгэхүйг судлахаар Японд ирсэн. Япон хэлээ сайжруулсны дараа агаарын тээврийн салбарт ажиллахыг зорин Japan College of Foreign Languages-д элсэн орсон. Агаарын тээврийн салбарт шаардлагатай ёс зүй болон мэдлэгийг надад зааж сургасан сургуулийнхаа ачаар Японд ажилд орж чадсан. Одоо Нарита онгоцны буудлын олон улсын шугамын ажилтнаар VIP lounge-д ажиллаж байна. Үйлчлүүлэгчдийн 80 хувь нь америкчууд байдаг тул сургуульдаа сурсан англи хэл их хэрэг болоод баяртай байдаг. Ирээдүйд Монголын агаарын тээврийн салбарт өөрийн сурсан мэдсэнд зориулан хувь нэмэр оруулахыг хүсч байна.

Japan College of Foreign Languages-ийг төгссөн
LKHAGVADOVJ KHERLEN Airport Terminal Service Co., Ltd.

Сурч буй оюутан



Япон хэлний сургууль → Professional Training College

Бэрхшээлтэй зүйл тохиолдсон ч сэтгэлээр уналгүй өөдрөгөөр урагш алхацгаая.

Japan Electronics College
NYAMDORJ ARSLAN

Япон улсын өндөр түвшний технологийг судлахаар хүрэлцэн ирсэн ба сургуульд электроникийн холбогдолтой төрөл бүрийн хичээлээр техник технологид суралцаж байна. Одоогийн байдлаар өндөр давтамжийн ороомог зохион бүтээх тал дээр ажиллаж байна. Улам бүр мэдлэгээ гүнзгийрүүлж хамгийн сүүлийн үеийн технологиор мэргэшилхийг хүсч байна. Би Японд суралцсанаар Японы ая тухтай амьдралыг мэдэрч Япон болон бусад орны олон найз нөхөдтэй болсон. Өөртөө төлөвлөгөө гаргаж өөрийн сонгосон замаас хазайлгүй мөрөөдлөө биелүүлэхийн төлөө хичээвэл ямар ч мөрөөдөл заавал биелэнэ гэж боддог тул та бүхэн өөдрөгөөр хичээгээрэй.

Сурч буй оюутан



Япон хэлний сургууль → Professional Training College

1-р зэрэглэлийн архитектор болоод мэргэжлээрээ Монголд ажилламаар байна

Syusei Technical College
GANZORIG TAMIR

Японы барилга архитектур дэлхийд номер нэг гэж боддог. Японы барилгын технологийг эзэмшиж тэр мэдлэгээ өөрийн орондоо ашиглан архитектураар ажиллахын тулд Японд ирсэн. Зураг төсөл, барилгын ажил, барилга бүтээц зэргийн үндсэн мэдлэг болон зураг зурах, компьютер, бүтээцийн тооцоо зэрэг амьдрал практик дээр бодитоор ашиглагдах зүйлсийг хүртэл хичээлээр судалсан. CAD ашиглаж хичээллэснээр компьютерийн мэдлэг ч мөн дээшилсэн гэж бодож байна. Туршилт болон дадлагын ажлаар үзсэн хичээлээ хир ойлгосноо турших боломжтой ба улам гүнзгийрүүлэн ойлгодог. Миний зорилго бол 1-р зэрэглэлийн архитектурын шалгалтад тэнцэх явдал юм. Үүний тулд өдөр бүр шамдан суралцаж байна.

Төгсөгч



Гадаад → Professional Training College → Их сургуульд дэвшин орсон

Монголын үйлчилгээний салбарын хөгжилд хувь нэмэр оруулах нь миний зорилт.

Өндөр түвшний үйлчилгээ, технологийг сурахын тулд Professional Training College-д элсэн орсон. Зочид буудлын бизнес болон үйлчилгээний харилцааны талаар судалж, үйлдвэрлэлийн дадлагаар дамжуулан практик чадварт суралцсан. Монгол болон Японы байгууллага хоорондын ялгаа болон хүмүүсийн харилцааны талаар судлах нь их сонирхолтой байсан. Shiga University-д Хүний нөөцийн удирдлага, Олон улсын менежмент зэрэг семинарыг сонгон судалж, жил бүр зохиогддог Менежментийн ухааны хамтарсан илтгэлийн улсын уралдаанд оролцсон. Менежментийн ухааны онгодсон сэдэвт тохируулан бизнес төлөвлөгөө боловсруулах нь сонирхолтой санагддаг. Ирээдүйд менежментийн зөвлөхөөр Монголын үйлчилгээний салбарт өөрийн хувь нэмрийг оруулна гэж бодож байна.

Travel Hospitality & Tourism Osaka College P-ийг төгссөн
GANBAT MUNKHTSETSEG Shiga University

Япон улс гадаад оюутнуудыг талархан хүлээн авч байна

Японд Professional Training College-иас гадна, Засгийн газар, боловсролын байгууллагууд, хувийн компаниуд зэрэг улс нийтээрээ гадаад оюутнууд та бүхнийг идэвхтэй хүлээн авч байна. Сэтгэл тайван амьдарч болох аюулгүй байдлын баталгаа, дэлхий нийтийн анхаарлыг татаж буй уламжлалт соёл, орчин үеийн хот, байгаль цогцолсон орчин зэрэг оюутны амьдралаа сэтгэл хангалуун өнгөрүүлэх нөхцөл бүрдсэн.

Японд суралцахын давуу тал

1 Дэлхийд дээгүүрт орох аюулгүй байдлын баталгаа

Япон нь аюулгүй байдлаараа дэлхийд дээгүүрт орох ба оюутны амьдралаа сэтгэл тайван өнгөрүүлэх боломжтой. Япончуудын халуун дулаан, эелдэг зан чанар нь олон зүйл дээр мэдрэгдэх болов уу.



2 Оюутны байр, орон сууцны хангамж сайтай

Олон Professional Training College нь гадаад оюутнууд амьдрах боломжтой оюутны байр, орон сууцтай байх эсвэл ийм газруудтай гэрээтэй байдаг. Амьдрахад тав тухтай, сургуульд ойрхон байр олдох нь лавтай.



3 Японы уламжлал, соёлыг мэдэх боломжтой

Орчин үеийн хот, үзэсгэлэнт байгаль, дэлхий дахины анхаарлыг татаж буй аниме, загварын соёл, шинэ шинэ нээлтээр дүүрэн өдрүүд та бүхийг хүлээж байна.



4 Сэтгэл хангалуун суралцах боломжтой

Японд суралцаж байсан гадаад оюутнуудын олонхи нь анкет судалгаагаар "Японд сурахад сайхан байсан" гэж өндөр сэтгэл ханамжтай хариулсан байна. Найрсаг зочломтгой Японы үйлчилгээ болон үндэсний онцлог, цагийн ажил хийнгээ санаа амар суралцах боломжтой орчин нөхцөл зэрэг бусад улсад байхгүйгээр сэтгэл хангалуун оюутан насыг өнгөрүүлэх боломжтой.

Төгссөний дараах Японы талаарх сэтгэгдэл

Төгссөний дараах Япончуудын талаарх сэтгэгдэл	Ангилал	Дээрдсэн	Муудсан	Хэлэхэд хэцүү	Тодорхойгүй	Нийт
Хамрагдагсдын тоо (хүн)		2,756	595	2,585	100	6,036
Хувь (%)		45.6	9.9	42.8	1.7	100.0

Японд суралцсан ерөнхий сэтгэгдэл	Ангилал	Сайн	Муу	Хэлэхэд хэцүү	Тодорхойгүй	Нийт
Хамрагдагсдын тоо (хүн)		5,480	67	467	22	6,036
Хувь (%)		90.8	1.1	7.7	0.4	100.0

(Эх сурвалж: 2015 оны JASSO-н судалгаагаар)

5 мэргэжлийн сургуулийн сургалтын ирээдүйн төлөв байдалд үзүүлэх нөлөө

Японд мэргэжлийн сургууль нь мэргэжлийн мэдлэг, ур чадвар эзэмшсэн, чухал боловсон хүчнийг бэлтгэх сургууль гэгдэх бөгөөд төгсөгчид нь олон салбарт амжилттай ажилладаг. Японыг дэлхий дахинд сурталчлах "Cool Japan" стратеги бодлого явагдаж, Япон орныг сонирхсон гадаад орнуудын сонирхол улам нэмэгдэж байгаагийн дагуу, анимэ, хувцас загвар, дизайн, хоол зэрэг "Cool Japan"-тай холбоотой салбарт ажиллахыг хүссэн гадаад оюутнуудын оршин суух статусын шалгуурыг тодотгож өгсөн. Асаргаа судалгааны салбарын хувьд Японы мэргэжлийн сургуульд асаргаа сувилагчийн мэргэжил эзэмшсэн гадаад оюутан Япон улсад ажил эрхлэх виз авах боломжтой болсон зэргээр засгийн газрын зүгээс ч гадаад оюутныг дэмжих бодлогыг хэрэгжүүлж байна. Мэргэжлийн сургууль төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь эдийн засгийн чиг хандлагыг харгалзахгүйгээр өндөр түвшинд байсаар байгаа нь ч онцлог юм.



Сургалтын төлбөр (Эхний жилд төлөх дүн)

Сургалтын төлбөр нь эхний жилд гарах элсэлтийн хураамж, хичээлийн төлбөрөөс гадна дадлагын хичээл болон шалгалтын төлбөр зэргээс бүрдэнэ. Уг дүн нь суралцах салбар болон сургуулиас хамааран харилцан адилгүй. Доорх дүн нь ойролцоогоор харуулсан дүн болно.

Хичээлийн төлбөр (иен)	471,000 ~ 1,109,000
Элсэлтийн хураамж (иен)	96,000 ~ 403,000
Нийт дүн (иен)	814,000 ~ 1,724,000
Нийт дүн (доллар)	8,140 ~ 17,240



*1 америк доллар = 100 иен байхаар тооцов *Өдрийн ангийн дундаж дүн (Мэдээллийн эх үүсвэр:TSK)
*Дээрх сургалтын төлбөр нь сурах салбараас хамааран харилцан адилгүй байна.

Цагийн ажил

JASSO-н судалгаанаас үзвэл, мэргэжлийн сургуулийн гадаад оюутны 83 орчим хувь нь цагийн ажил хийдэг. Ажлын төрөл тус бүрээр харахад хоолны газрын үйлчилгээ хамгийн их ба дараа нь худалдаа, борлуулалт, багшлах/судалгааны асистант, зочид буудлын ресепшн, заал хариуцагч зэрэг ажлууд тус тус ордог байна. Цагийн цалин нь ажлын төрөл, бус нутгаас хамааран харилцан адилгүй боловч хоолны газрын үйлчилгээний хувьд 800~1,200 иен орчим байдгаас үзвэл хуулиар заасан 1 долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар буюу 28 цаг ажиллавал сард ойролцоогоор 80~120 мянган иен болно. Цагийн ажил хийхийн тулд ойр байрлах Гадаадын иргэн харьяатын асуудал эрхэлсэн газраас оршин суух зорилгоос гадуур үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авах ба дараах нөхцлийг хангасны үндсэн дээр эрхэлж болно.

- ①Хичээл сурлагад сөргөөр нөлөөлөхгүй байх
- ②Цагийн ажлыг гадаадад суралцах хугацааны сургалтын төлбөр болон шаардлагатай зардлыг төлөхийн тулд хийх ба хуримтлуулах, гэр бүл рүү эгз илгээх зорилгогүй байх.
- ③Зугаа цэнгээний үйл ажиллагаа биш байх.
- ④Долоо хоногт 28 цагаас илүүгүй байх.
- ⑤Цагийн ажлыг зөвхөн боловсролын байгууллагад харьяалж байх хугацаандаа хийх.

2012 оны 7-р сарын 9-ний өдрөөс эхлэн Япон улсын хилээр нэвтрэх үед оршин суух үнэмлэх олгодог онгоцны буудал (өнөөдрийн байдлаар зөвхөн Нарита, Ханэда, Чүбү болон Кансай нисэх онгоцны буудлууд) -д оршин суух зорилгоос гадуур үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авах өргөдөл гаргах боломжтой болсон.

*Зөвшөөрөл авалгүйгээр ажилласан тохиолдол болон зөвшөөрөгдсөн цаг болон үйл ажиллагааны агуулгыг зөрсөн тохиолдолд ял шийтгэх, албадан гаргах зэрэг арга хэмжээ авдаг.

Цагийн ажлыг сурч буй сургууль, орон даяарх Нийтийн хөдөлмөр эрхлэлтийн баталгааны газар "Hello work" зэрэг газруудаас санал болгодог.

Гадаад оюутнуудын зонхилох цагийн ажлууд

	Ажлын төрөл	Хувь
1	Хоолны газрын үйлчилгээ	45.7%
2	Худалдаа, борлуулалт (Дөг дэлгүүр зэрэг)	26.3%
3	Багшлах/судалгааны асистант	6.9%
4	Бичгийн болон аман орчуулга	6.8%
5	Гадаад хэлний багш	6.5%
6	Цэвэрлэгээ	5.1%
7	Зочид буудлын ресепшн, заал хариуцагч	5.0%
8	Гэрийн багш	4.6%
9	Оффисын ажил	4.4%
10	Үйлдвэрт угсрах ажил	4.3%

(Эх сурвалж: 2015 оны JASSO-н судалгаагаар)

Гол орлого ба зарлагын дүнгийн жишээ

		Эцэг эх, ах дүү, хамаатан садан руугаа мөнгө явуулах	Цагийн ажил	Орлогын нийт дүн	Сургалтын төлбөр	Хоолны мөнгө	Байрны төлбөр	Зарлагын нийт дүн
Мэргэжлийн сургууль	Ханз үсэг хэрэглэдэг бүс	96,234	82,050	166,088	66,129	31,818	42,908	166,063
	Ханз үсэг хэрэглэдэггүй бүс	62,751	93,007	151,932	56,235	24,267	31,749	145,340

(JASSO-н судалгаагаар)


Нийт мөнгөн дүнд дээр бичсэнээс бусад мөнгийг ч оруулсан байгаа.

Professional Training College-ийн гарын авлага 平成29年度 文部科学省委託事業 専修学校グローバル化対応推進支援事業

2018 оны 1 сарын 30 өдөр хэвлэгдсэн

- [Редактор, хэвлэсэн] 一般財団法人 職業教育・キャリア教育財団
Association for Technical and Career Education
102-0073 Токио хот, Чиода-Ку, Куданкита 4-2-25, Шигаку ордон, 11 давхар
TEL: +81-3-3230-4814 <http://www.sgec.or.jp/>
- [Хянан тохиолдуулсан] 「専修学校グローバル化対応推進支援事業」情報提供事業分科会
[Хамтарсан редактор] 株式会社アクセスリード
[Албан ёсны вэб хуудас] <http://www.sgec.or.jp/ryuugakuguide/index.html>

Япон улсад зорчих процедур



Оршин суух зөвшөөрөл хүсэх өргөдөл

[Өргөдөл гаргагч]

- Гадаадад суралцахыг хүсэгч өөрийн биеэр
 - Төлөөний этгээд (Хүлээн авах байгууллагын ажилтан зэрэг)*
- *Ихэнх тохиолдолд төлөөний этгээдээр дамждаг.

[Шаардлагатай материал]

- Оршин суух зөвшөөрөл хүсэх өргөдөл
- Цээж зураг
- Хариу илгээх зориулалтын дугтуй
- Бусад Хүлээн авах байгууллагаас хамаарч бүрдүүлэх материал харилцан адилгүй байх тул тухайн байгууллагаас тодруулна уу.

Виз мэдүүлэх

"Оршин суух зөвшөөрөл" олгогдсоны дараа өөрийн улсад суугаа Япон улсын элчин сайдын яаманд мэдүүлэх.

[Шаардлагатай материал]

- Паспорт
- Виз хүсэх өргөдөл
- Цээж зураг
- Оршин суух зөвшөөрөл

*Дээрхээс гадна өөр бичиг баримт шаардаж болно.

